




УЛААНБААТАР,
ГЭР ХОРООЛОЛ

“ДУЛААН ШИЙДЭЛ” ТӨСӨЛ (2018-2021)



“Дулаан шийдэл” төсөл



Mongolia



ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Засгийн газар 2017 онд агаарын бохирдлыг гамшгийн хэмжээнд хүрснийг зарлаж, агаарын бохирдлыг бууруулах гарцыг олоход идэвх санаачилга гарган ажиллаж эхэлсэн. Улаанбаатар хотын агаарын бохирдлын гол эх үүсвэр болох, гэр хорооллын иргэдийн хувийн сууцны дулаан алдагдлыг багасгах нь асуудлыг шийдэх гол алхам юм. “Дулаан шийдэл” төсөл 2018 оноос эхлэн 4 жилийн хугацаатай хэрэгжиж байгаа бөгөөд гэр хорооллын хувийн сууцыг дулаалж, дулаан алдагдлыг багасгаснаар агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулах зорилготой. Уг төслийг Жэрэс олон улсын ТББ нь ШУТИС-ийн Барилгын эрчим хүчний хэмнэлтийн төв, Монголын барилгын үндэсний ассоциаци, Пипл Ин Нийд олон улсын ТББ-уудтай хамтран Европын холбоо, Свич Эшиа хөтөлбөр, Абби пиер сан, Чехийн болон Францийн хөгжлийн агентлагуудын санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжүүлж байна.

Төслийн зорилго

- Улаанбаатар хотын гэр хороололд дулааны алдагдал багатай байшин барихад дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэхийг зорино.
- Гэр хорооллын айл өрхүүдийн нүүрсхүчлийн хий болон нарийн ширхэгт тоосонцорын хэмжээг бууруулснаар оршин суугчдын зан үйл, хандлагад нөлөөлж, Бичил, Жижиг, Дунд бизнес эрхлэгчдэд (БЖДБ) мэргэжил, арга зүйн хувьд дэмжлэг үзүүлнэ.

Төслийн үйл ажиллагаа – Суурь судалгааны тайлан хэвлэгдэн гарав.

- Айл өрхийн дулаан алдагдал, агаарын бохирдлын тухай мэдлэг хандлагыг ойлгох зорилготой Судалгааны тайланг боловсруулав. Уг судалгаагаар дамжуулан айл өрхүүдийн санхүүгийн нөхцөл байдал, чадамж, цаашдын хэрэгцээг тодорхойлов.
- Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй байшин сууцтай айл өрхүүдийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, хадгаламжтай болох байдлыг судлах, ойлгох зорилго бүхий Судалгааг хийж гүйцэтгэв.
- Гэр хорооллын хувийн сууцны ангилал, халаалтын эх үүсвэрийн тухай судалгаагаар орон сууцны хэв маяг, барихдаа гаргадаг нийтлэг алдааг тогтоож, тухайн байшингуудын дулаан алдагдлын эх үүсвэрүүдийг тодорхойлов;
- Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэмжээнд барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй БЖДБ эрхлэгчид, бригадуудын мэдээллийн санг бүрдүүлэх судалгаагаар тэдний ажлын туршлага, мэргэжлийн чадавх, эдийн засгийн үзүүлэлт, ажиллах хүчний мэдээллийг бүрдүүлэв.
- Монголын Барилгын Үндэсний Ассоциацид эрчим хүчний хэмнэлттэй барилгын салбарт ажиллаж буй БЖДБ бизнес эрхлэгчдийг ногоон ажлын байранд зуучлах, сургаж, дадлагажуулах зорилгоор **Салбар** байгуулав.

ТӨСЛИЙН ТУХАЙ

Төслийн нэр: Дулаан шийдэл
Үргэлжлэх хугацаа: 2018-2021 он
Төсөв: 2,191,896 Евро

Зорилтот бүлгүүд:

- Гэр хороололд амьдарч буй иргэд
- Барилгын салбарын Бичил, Жижиг, Дунд Бизнес эрхлэгчид
- Улсын болон орон нутгийн засаг захиргаа
- Санхүүгийн байгууллагууд
- Барилгын компани, мэргэжилтнүүд
- Олон улсын хөгжлийн агентлагууд

Зорилтот бүс нутаг:

Улаанбаатар хотын гэр хороолол

ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Дулаалгын зах зээлийн загварыг бий болгов. Гэр хороололд амьдарч буй айл өрхүүдийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн, чанарын шаардлага хангасан материалаар дулаалгын ажлыг өндөр түвшинд хийж гүйцэтгэж байна.

- Дулаалгын талаарх мэдээлэл, үйлчилгээг иргэдэд хүргэх, дулаалгын анхан шатны тооцооллыг бодох, зээлд хамрагдах шалгуурын тухай www.dulaalga.mn вебсайтнаас мэдээлэл авч болно. Мөн зах зээлийн оролцогч талууд бүртгэл оруулах, дулаалгын үйл явцыг хянах зорилгоор ашиглаж байна.
- Хэрэглэгчдийг илүү сайн ойлгохын тулд дулаалгын зах зээлийн судалгааг байнга хийж байна.
- Төслийн хүрээнд Монгол улсад баригдсан байшин сууцыг ханын материалын төрлөөр нь үндсэн 4 төрөлд ангилж, тэдэнд зориулсан **5 өөр төрлийн материалаас бүрдсэн 2 өөр дулаалгын шийдлийг** санал болгож байна.
- **“Дулаан шийдэл төсөл”** Фэйсбүүк хуудас, **+976-75052000** Дуудлагын төвийг хамтад нь ажиллуулж зорилтот айл өрхүүдэд хүрэх сурталчилгааны гол суваг болгон ашиглаж байна.
- **Төслийн боловсруулсан эрчим хүчний зөвлөхийн үнэлгээ, дулаалгын чанарын шалгалтын маягт** Барилгын дулаан хамгаалалтын шинэчлэгдсэн нормд багтав.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

- Эрчим хүчний хэмнэлттэй хувийн сууцын стандартчилагдсан техникийн шийдэл, зөвлөмжийг тодорхойлж, холбогдох мэргэжилтэн, айл өрхүүдэд түгээсэн байна.
- Барилгын салбарт ажиллаж буй оролцогч талууд дулаалгын ач холбогдлыг таниулан, чанартай хийж гүйцэтгэх чадамжтай болсон байна.
- Дулаалгын ач холбогдол, шийдэл, хэрэглээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хамгийн багадаа 400,000 хүнд хүргэнэ. Дулаалгыг хамгийн хямд төсөр шийдлээс эхлэн бүтэн багц хүртэл алхам алхмаар хийж болох бөгөөд уг ойлголтыг олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.
- Дулаалгын зах зээлийн загварыг сайжруулж, илүү олон оролцогч талыг хамруулна.
- 1000 өрх, дулаалгын ямар нэгэн шийдлыг хэрэгжүүлснээр Улаанбаатар хотын хэмжээнд 3000 тонн нүүрсхүчлийн хийг бууруулж, 800 тонн нүүрс хэрэглэхээс сэргийлж чадна



Санхүүжүүлэгчид:

switchasia
GRANTS PROGRAMME



Хэрэгжүүлэгч байгууллагууд:



Хамтын ажиллагаа:



www.geres.eu



ХОЛБОО БАРИХ

Биатриз Марото Изкиердо
Монгол дахь суурин төлөөлөгч
/Төслийн зохицуулагч/
b.maroto-izquierdo@geres.eu

Идэрсайханы Одончимэг
Олон нийттэй харилцах
ажилтан
o.idersaikhan@geres.eu
+(976)7505-2000

Хаяг:

Жэрэс ОУ ТББ, Монгол дахь төлөөлөгчийн газар
Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р
хороо, Жуулчны гудамж, Дельта оффис, 4 давхар,
403 тоот, Имэйл: mongolia@geres.eu